



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн давтан аудитын тайлан

МЭРГЭЖИЛ СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙН ДАВТАН АУДИТ



**ӨМНӨХ АУДИТААС ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ 87.3 ХУВИЙН
ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙГАА Ч ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ ЗАРИМ МСҮТ-ҮҮДЭД ГАРСАН БАЙНА.**



АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:		
Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
Тэргүүлэх аудитор Д. Уламбаяр	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	2-4
Аудитын менежер Т.Байгалмаа	Бүлэг 1.	5
Аудитор Г.Цог-Эрдэнэ Х.Алтанчимэг	ӨМНӨХ АУДИТААС ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 87.3 ХУВЬТАЙ БАЙНА	5
	1.1. Төлбөрийн актны 25 хувийг хэрэгжүүлээгүй байна.	5
	1.2. Зөрчил арилгуулах албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн байна.	6
	1.3. Зөвлөмжийн хэрэгжилт 87 хувьтай байна.	7
2017 оны 11 дүгээр сар	Бүлэг 2.	8
Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	АУДИТЫН МӨРӨӨР ТОДОРХОЙ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСАН Ч ҮР ДҮН БАГАТАЙ БАЙНА	8
www.audit.mn	2.1. Аудитын дүнд үндэслэн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж ажилласан байна.	8-9
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70332860 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу	2.2. Аудитаас өгсөн зөвлөмжийн мөрөөр тодорхой ажлууд хэрэгжүүлсэн боловч үр дүнг тооцож ажиллаагүй байна.	10-12
	2.3. Давтан аудитаар 2017 оны 3-улирлын байдлаар санхүүгийн үйл ажиллагааг шалгахад зөрчлүүд давтан гарсан байна.	12-13
ХАЯГ:	ДҮГНЭЛТ.....	14
ᠶᠳᠠᠭᠢ ᠶᠠ᠋᠋᠋᠋᠋᠋ ᠨᠣ᠋᠋ ᠠᠡ᠋᠋᠋ ᠴᠠ᠋᠋᠋᠋᠋᠋ ᠠ᠋᠋᠋᠋᠋ 3-ᠳ ᠠ᠋᠋᠋᠋᠋᠋ 311 ᠋᠋᠋᠋᠋	ЗӨВЛӨМЖ.....	15
	УАГ-Т УЛАМЖЛАХ САНАЛ	16
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	17-19
	ХАВСРАЛТУУД	
	1. АЛБАН ШААРДЛАГА	19-20
	2. ИЛРҮҮЛЭЛТИЙН БҮРТГЭЛ	21-22
	3. ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	23-24
	4. ЗӨВЛӨМЖ	25-26



Товчилсон үгийн жагсаалт

<i>АРХ</i>	<i>АРХАНГАЙ АЙМАГ</i>
<i>ҮАГ</i>	<i>ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР</i>
<i>МУЕА</i>	<i>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР</i>
<i>ДА</i>	<i>ДАВТАН АУДИТ</i>
<i>МСҮТ</i>	<i>МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ</i>
<i>МХГ</i>	<i>МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР</i>
<i>ДХЗ</i>	<i>ДОТООД ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ</i>
<i>МБСДС</i>	<i>МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫГ ДЭМЖИХ САН</i>
<i>АДБОУС</i>	<i>АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ</i>
<i>АШБ</i>	<i>АНХАН ШАТНЫ БАРИМТ</i>
<i>МБСБС</i>	<i>МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧ</i>
<i>ДУБ</i>	<i>ДАДЛАГА УДИРДСАН БАГШ</i>
<i>НА</i>	<i>НИЙЦЛИЙН АУДИТ</i>

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ᠠᠳᠠᠭᠡᠨ ᠶ᠋ᠢ нэр: Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тэтгэлэг олгох журмын хэрэгжилтийн давтан аудит

Аудитын код: АРХ-/2017/03-НА-ДА

Àóäèòû í хийх үндэслэл:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын Ерөнхий аудиторт Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Àóäèòû í çî ðèëò:

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн дагуу “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-гаас аймгийн МСҮТ-үүдэд олгосон хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний болон акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд аудит хийж үнэлэх мөн суралцагчдын хамрагдалтыг газар дээр нь тулган шалгаж дүнг МСҮТ-үүдэд танилцуулах, цаашид зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх боломжит арга хэмжээг авч бодит үр дүнд хүрэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн эсэх
- Аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй эсэх

Ồàì aỗcàh ỗừỗứ:

Өмнөх аудитаар Хөдөлмөрийн яамны харъяа Архангай МСҮТөв, хувийн өмчит “Гурвантамир”, “Булган”, “Дэд бүтэц” зэрэг МСҮТөвүүдэд хүргүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт болон аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ холбогдох хууль, журамд нийцсэн эсэхэд МСҮТөвүүдийг хамруулан шалгалаа.

Àóäèòû í àďǎà ççé:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын удирдамж (АДБОУС 4000), нийцлийн аудитын түр журмыг ашиглан холбогдох иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, хүрсэн үр дүнг үндсэн үзүүлэлттэй харьцуулах, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх зэргээр Тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний аргазүйг ашиглан аудитын хөтөлбөр горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журамд заасны дагуу



аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлсийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

- Засгийн газрын тусгай сангийн хууль.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль.
- Засгийн газрын 2011 оны 117 тогтоол */Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүний хяналт тавих журам/*
- Засгийн газрын 2007 оны 294 тогтоол */Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам/*
- Засгийн газрын 2015 оны 477 тогтоол */Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам/*
- Засгийн газрын 2012 оны 94-р тогтоол */Зардлын дундаж норматив батлах тухай/*
- Шилэн дансны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тухай хуультай нийцүүлэн гаргасан дүрэм, журам
- Аймаг дахь Төрийн Аудитын газрын 01/86 YAГ-НАГ-/2016/03-НА, 02/87 YAГ-НАГ-/2016/03-НА, 04/89 тоот албан шаардлагууд
- Аймаг дахь Төрийн Аудитын газрын 01/28 YAГ-НАГ-/2016/03-НА, 02/28 YAГ-НАГ-/2016/03-НА, 04/89 YAГ-НАГ-/2016/03-НА, 01/28 YAГ-НАГ-/2016/03-НА, 04/90 ААГ-/2016/01-ГА тоот актууд
- YAГ-НАГ/2016/03-НА кодтой Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлан болон зөвлөмжүүд

Оршил

Өмнөх аудитаар аймгийн аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын хэрэгжилтэд Хөдөлмөрийн яамны харъяа Архангай аймгийн МСҮТөв, хувийн өмчит “Гурвантамир”, “Булган”, “Дэд бүтэц” зэрэг МСҮТөвүүдийн 2015-2016 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг хамруулан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалтын үр дүнг шалгасан. Энэ аудитын дүнгээс 3.0 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулах талаар 4 актыг Хөдөлмөрийн яамны харъяа Архангай аймгийн МСҮТөв, хувийн өмчит “Гурвантамир”, “Булган”, “Дэд бүтэц” зэрэг МСҮТөвүүдэд, 85.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг “Гурвантамир”, “Булган”, “Дэд бүтэц” МСҮТөвүүдэд мөн НББтухай хуулийн дагуу тайлан мэдээг гаргах, сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чадамжийн хүрээний хичээлүүдийг заах боловсон хүчний асуудлыг шийдвэрлэх, сангийн хөрөнгөнд тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, МБСБСуралцагчид тэтгэлэг олгох журмыг мөрдөж, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахад чиглэсэн 13 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлсэн



байна. Үүнээс 2.2 сая төгрөг буюу 73.1 хувийн актыг, 85.7 сая төгрөг буюу 100 хувийн албан шаардлагыг биелүүлсэн тухай албан бичиг, нотлох баримтуудыг Хөдөлмөрийн яамны харъяа Архангай аймгийн МСҮТөв, хувийн өмчит “Гурвантамир”, “Булган”, “Дэд бүтэц” зэрэг МСҮТөвүүдээс тус тус ирүүлсэн. Харин аудитаар тогтоогдсон актны биелэлтийг Хөдөлмөрийн яамны харъяа Архангай аймгийн МСҮТөвөөс гаргаж ирүүлээгүй байна.

Өмнөх аудитаар өгсөн 13 заалт бүхий зөвлөмжийн биелэлтийг холбогдох байгууллага тус бүр дээр нэг бүрчлэн тулган шалгаж үр дүнг тооцохоор төлөвлөсөн.

БҮЛЭГ 1.


ӨМНӨХ АУДИТААС ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 87.3 ХУВЬТАЙ БАЙНА

1.1. ТӨЛБӨРИЙН АКТНЫ 25 ХУВИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

2015-2016 оны хичээлийн жилд давхардан суусан 6 суралцагчийн 3 сарын тэтгэлгийн санхүүжилт болох 809.1 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүй байна.

Өмнөх аудитаар 2015-2016 оны хичээлийн жилд давхардан суусан 17 суралцагчийн тэтгэлэгийн санхүүжилт болох 3,060.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх талаар 4 актыг МСҮТөвүүдэд хүргүүлсэн.

Давтан аудитын явцад актны барагдуулалтыг судалгаагаар авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:



Дээрх графикаас харахад өмнөх аудитаас тогтоосон 4 актны 3,060.1 мянган төгрөгний 75 хувь буюу 2,251.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.



1.2. ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ АЛБАН ШААРДЛАГЫГ 100 ХУВЬ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

АЛБАН ШААРДЛАГЫН МӨРӨӨР ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАН ҮР ДҮНТЭЙ АЖИЛЛАСАН БАЙНА.

Дэд бүтэц МСҮТөв: Өмнөх аудитаас 811.4 мянган төгрөгийн үнэтэй 14ш нормын хувцсыг дутагдуулсан зөрчилд нөхөн бүрдүүлэх, сангийн хөрөнгөөр бэлтгэсэн бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, бүртгэлээр тавих хяналтыг хэвшүүлэх талаар албан шаардлага өгсөн.

Албан шаардлагын мөрөөр үйлдвэрлэлийн дадлагын үеэр эмх замбараагүй тараагдсан ажлын хувцаснуудыг нөхөн бүрдүүлж бүртгэсэн байна. Мэргэжлийн багш нарт дахин хувцас дутаахгүй байхыг анхааруулан хариуцлага тооцон суралцагчдад картаар хүлээлгэн өгч, дадлага тарахад картын дагуу хураан авдаг хэвшлийг бий болгож ажилласан байна.

Гурвантамир МСҮТөв: 2015 онд 16 сая төгрөг, 2016 онд 6.6 сая төгрөг нийт 22.6 сая төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримтын бүрдэл дутуу, бүртгэл тайлагнал нь хангалтгүй зөрчил дутагдлыг арилгах талаар албан шаардлага өгсөн. Албан шаардлагын мөрөөр анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг баримтжуулах, баримт падаануудыг ерөнхий журналтай тулган шалгаж тайланд хавсаргах ажлуудыг хийсэн байна. 2017 оны 01 сараас 06 сарын 30-ны байдлаар МБСДСангаас олгосон санхүүжилтийн зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган шалгахад АШБ-ын бүрдэл дутуу ажил гүйлгээ гараагүй байлаа.

Булган МСҮТөв: 2015-2016 оны хувьсах зардлаас барилгын болон тогоочийн ангийн суралцагчдад зарцуулсан 62.3 сая төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн зардлын холбогдох баримт материал, тооцоог аудитад хамруулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.


Албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Төлөвлөгөөгөөр хичээл үйлдвэрлэлийн зардлын тооцоог мэргэжил тус бүрээр тооцож аудитад хамруулсан байна.

1.3. ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 87 ХУВЬТАЙ БАЙНА.

Өмнөх аудитын дүнгээс МБСДСангийн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулах, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах, сангийн хөрөнгөөр бэлтгэсэн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, багш нарын чадварыг нэмэгдүүлэх үүднээс багшлах эрхийн үнэмлэх олгох сургалтанд хамруулах, суралцагчдын ажлын байранд олгох чадамжийг үр дүнтэй зохион байгуулахад чиглэсэн 13 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн юм. Тухайлбал: Булган МСҮТөвд 2, Гурвантамир МСҮТөвд 5, Дэд бүтэц хангай МСҮТөвд 6 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд 2017 оны 10 дугаар сарын байдлаар нийт зөвлөмжийн 87 хувийг биелүүлсэн байна.



Өмнөх аудитаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг графикаар харуулбал:



Өмнөх аудитын дүнгээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 2-р бүлгээс үзнэ үү.

Аудитаас Гурвантамир, Дэдбүтэц хангай, Булган МСҮТөвүүдэд хүргүүлсэн дараах 4 зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна. Үүнд:

- ЗГ-ын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах талаархи 3-н зөвлөмжийг Булган, Гурвантамир, Дэдбүтэц хангай МСҮТөвүүдэд хүргүүлсэн. МСҮТөвүүдэд суралцагчдын тэтгэлэг нь 2015 оны 09-р сараас суралцагчдын данс руу яамнаас шууд шилжүүлдэг болсон бөгөөд тэтгэлэг олголт 2016 оны 03-р сараас хойш тодорхойгүй хугацаагаар зогссон тул энэ заалт МСҮТөвүүдэд хэрэгжих боломжгүй гэж үзэхэд хүргэж байна. Иймд зөвлөмжийн биелэлтийг үнэлгээнд оруулж тооцоогүй болно.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18.1-18.3¹ дахь заалтуудыг баримтлан ажиллах талаархи 1 зөвлөмжийг Дэдбүтэц хангай МСҮТөвд өгсөн. Зөвлөмжийн дагуу багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, багшлах эрхийн үнэмлэх олгох сургалтанд хамруулаагүй, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй байгаа нь зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзэхэд хүргэж байна. 2017 оны 09 дүгээр байдлаар үйл ажиллагаа нь зогссон, элсэлт аваагүй, УБ хотруу шилжсэн мэдээлэлтэй байна.

Мөн Хуулийн дагуу сангийн зарцуулалтын тайланг зардлын зүйлээр тайлагнаж холбогдох байгууллагад хүргүүлж байх талаархи 1 зөвлөмжийг

¹ 18.1-д "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна"

18.2-д "Мэргэжлийн сургалтыг хөтлөн удирдах багш нь үйлдвэрлэл, технологийн туршлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна"

18.3-д "Багшийн мэргэжил эзэмшээгүй орон тооны багш нь сургалтын заах арга зүй эзэмшиж, багшлах эрхийн үнэмлэх авсан байна"

¹ НББТухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"



Гурвантамир МСҮТөвд өгсөн. Зөвлөмжийн хариу тайлбарт: Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн яам нь МБСДСангаас олгож байгаа хувьсах зардлыг зардлын зүйлээр хувиарладаггүй 2-3 сард 1 удаа санхүүжилт тавигдаж байгаа тайланг хүлээн авахдаа хоорондын тооцоогоор тулгаж хүлээн авдаг гэсэн байна. Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг 50 хувиар тооцсон болно.

БҮЛЭГ 2

АУДИТЫН МӨРӨӨР ТОДОРХОЙ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСАН Ч ҮР ДҮН БАГАТАЙ БАЙНА

2.1. АУДИТЫН ДҮНД ҮНДЭСЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА.

Гурвантамир МСҮТөв 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд аудитын мөрөөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгаж Ерөнхий захиралаар батлуулсан байна. Үүнд:

1. Албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллах үүднээс АШБ-ын бүрдэл дутуу ажил гүйлгээнүүдийн бүрдэлийг хангах мөн 2017 оны МБСДСангийн хөрөнгийг АШБ-ын бүрдэлийг хангаж зарцуулах
2. Сангийн хөрөнгөнд тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, дотоод хяналтын төлөвлөгөө, удирдамжийг боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах
3. Актаар тогтоогдсон төлбөрийг цаг хугацаанд нь орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх

Төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзэхэд:

1. Өмнөх аудитаар илэрсэн АШБ-ын бүрдэл дутуу ажил гүйлгээнүүдийг баримтжуулж, баримт падаануудыг ерөнхий журналтай тулган шалгаж биелэлтийг 2016 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 16/36 тоот албан бичгээр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна. Давтан аудитаар 2017 оны МБСДСангийн хөрөнгийн зарцуулалтыг баримтаар тулган шалгахад АШБ-ын бүрдэл дутуу ажил гүйлгээ гараагүй байгаа нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлага бүрэн хэрэгжсэн гэж үзэхээр байна.
2. Дотоод хяналтын ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан МСҮТөвийн санхүүгийн болон сургалтын үйл ажиллагаа, багш нарын ажлын гүйцэтгэлд хяналт хийж, тайлан мэдээг багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажилласан байна.
3. 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/28 дугаар бүхий актаар тогтоогдсон 5 суралцагчдад давхардуулан олгосон 1050.0 мянган төгрөгийн тэтгэлгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд 100% төвлөрүүлсэн байна.

Булган МСҮТөв 2016 оны 10-р сарын 17-ны өдрийн багш нарын хурлаар аудитын мөрөөр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгаж батлуулсан байна. Үүнд:



1. Албан шаардлагын мөрөөр хичээл үйлдвэрлэлийн дадлагын ажилд шаардагдах материалын тооцоог мэргэжил тус бүрээр гаргаж аудитад хамруулах
2. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18.1-18.3 дахь заалтуудыг баримтлан ажиллах
3. Актаар тогтоогдсон төлбөрийг барагдуулж ажиллах

Төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзэхэд:

1. МСҮТөвийн суралцагчдын хичээл үйлдвэрлэлийн сургалтын зардлын тооцоог мэргэжил тус бүрээр нарийвчлан тооцон гаргаж 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 78 тоот албан бичгээр аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.
2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 2017 оны 01 сард багшлах эрхийн үнэмлэх олгох сургалтанд 4 багшийг хамруулж ажилласан байна. Мөн ирэх оны 01 сард шинээр орсон 3 багшийг багшлах эрхийн үнэмлэх олгох сургалтанд хамруулахаар бэлтгэж байна.
3. 2016 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 03/31 дугаар актаар тогтоогдсон 3 суралцагчдад давхардуулан олгосон 630.0 мянган төгрөгийн тэтгэлгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд 100% төвлөрүүлсэн байна.

Дэд бүтэц хангай МСҮТөв 2016 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 26 тоот захирлын тушаалаар аудитын мөрөөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгаж батлуулсан байна. Үүнд:

1. Албан шаардлагын мөрөөр 2015-2016 оны хичээлийн жилд сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 811.4 мянган төгрөгийн үнэтэй 14ш дадлагын нормын хувцасыг нөхөн бүрдүүлэх
2. Сангийн хөрөнгөнд тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах
3. Дадлага хийх хугацаанд дадлага удирдсан багш нарт тавих хяналтыг сайжруулж, 3-н талт гэрээг баримтлан суралцагчдын ажлын байранд олгох чадамжийг үр дүнтэй зохион байгуулахад анхаарч ажиллах
4. Актаар тогтоогдсон төлбөрийг барагдуулж ажиллах

Төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзэхэд:

1. Үйлдвэрлэлийн дадлагын үеэр эмх замбараагүй тараагдсан 811.4 мянган төгрөгийн үнэтэй 14ш дадлагын нормын хувцасыг нөхөн бүрдүүлж бүртгэн биелэлтийг 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 11 тоот албан бичгээр аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.
2. Тус МСҮТөв дотоод хяналтын журмыг шинэчлэн ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж санхүү болон МСҮТөвийн үйл ажиллагаанд хяналт тавьж зөрчил дутагдалыг тухай бүр арилгаж ажилласан байна.
3. Дадлагын хугацаанд дадлага удирдсан багш нарт сургалтын албаны зүгээс хяналт тавин ажиллаж үйлдвэрлэлийн дадлагын гурвалсан гэрээг 4 байгууллагатай байгуулан дадлагын үр дүнг дүгнэн ажилласан байна. Мөн хамтран ажиллагч байгууллагуудад дадлагын удирдамжийн дагуу ажлуулах дадлагыг үр дүнтэй хийлгэх талаар санал шаардлага тавин ирцийг ДУБагш бүртгэж 81 суралцагчаас 60 суралцагч буюу 74 хувь нь дадлагад хамрагдсан байна.



4. 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 02/28 дугаар актаар тогтоогдсон 3 суралцагчдад давхардуулан олгосон 571.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд 100 хувь төвлөрүүлсэн байна.
5. Давтан аудитаар 2017 оны 01 сараас 06 сарын 30-ны байдлаар МБСДСангийн хөрөнгийн зарцуулалтыг баримтаар тулган шалгахад АШБ-ын бүрдэл дутуу ажил гүйлгээ гараагүй байгаа нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлага бүрэн хэрэгжсэн гэж үзэхээр байна.

Архангай МСҮТөв өмнөх аудитаар өгсөн актыг бүрэн барагдуулаагүй байгаа нь аудитаас өгсөн шийдвэрийн мөрөөр тодорхой арга хэмжээ аваагүйг харуулж байна.

2.2. АУДИТААС ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН МӨРӨӨР ТОДОРХОЙ АЖЛУУД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ҮР ДҮНГ ТООЦОЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

А. Булган МСҮТөвд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнгийн талаар:

Өмнөх аудитын дүнгээс Булган МСҮТөвд дараах зөвлөмжийг хүргүүлсэн юм. Үүнд:

1. ЗГ-ын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам"-ыг мөрдлөг болгон ажиллах
 - МСҮТөвийн суралцагчдын тэтгэлэг нь 2015 оны 09 дүгээр сараас сурагчдын дансруу яамнаас шууд шилжүүлдэг болсон бөгөөд тэтгэлэг олголт 2016 оны 3 дугаар сараас тодорхойгүй хугацаагаар зогссон тул энэ заалт хэрэгжээгүй тодорхой үр дүнд хүрээгүй байна.
2. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18.1-18.3 дахь заалтуудыг баримтлан ажиллах
 - Энэ зөвлөмжийн мөрөөр 2017 оны 01 дүгээр сард багшлах эрхийн үнэмлэх олгох сургалтанд 4 багшийг хамруулж ажилласан байна. Мөн ирэх оны 01 дүгээр сард шинээр багшилж байгаа 3 багшийг багшлах эрхийн үнэмлэх олгох сургалтанд хамруулахаар бэлтгэж байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр төлөвлөгөө боловсруулж ажилласан боловч ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж ажиллаагүй байна.

Б. Гурвантамир МСҮТөвд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнгийн талаар

Өмнөх аудитын дүнгээс Гурвантамир МСҮТөвд дараах зөвлөмжийг хүргүүлсэн юм. Үүнд:

1. Сангийн хөрөнгөнд тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах
 - Дотоод хяналтын ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан МСҮТөвийн санхүүгийн болон сургалтын үйл ажиллагаа, багш нарын ажлын гүйцэтгэлд хяналт хийж, тайлан мэдээг багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажилласан байна.



2. Хуулийн дагуу сангийн зарцуулалтын тайланг зардлын зүйлээр тайлагнаж холбогдох байгууллагад хүргүүлж байх
 - Тус МСҮТөвөөс зөвлөмжийн хариу тайлбарт: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам нь МБСДСангаас олгож байгаа хувьсах зардлыг зардлын зүйлээр хувиарладаггүй, оны эхэнд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулдаггүй, дараа оны төсөв ч хийлгэхгүй байгаа нь хүндрэлтэй байна. Мөн хувьсах зардлын санхүүжилт сар бүр орж ирдэггүй 2-3 сар болоод 1 удаа санхүүжилт тавигдаж байгаа нь бидний санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт хэрэгжихгүй, мэдээ тайлан гаргахад хүндрэлтэй байна. Тухайн онд олгосон санхүүжилтээр тайлан гаргаад яаманд хүргүүлэхэд тайланг хүлээн авдаггүй хоорондын тооцоогоор явна гэдэг иймд бидний ажилд биш яамны санхүүгийн албадын ажилтай шууд холбоотой байна гэсэн хариу тайлбар өгсөн байна.

В. Дэд бүтэц хангай МСҮТөвд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнгийн талаар

1. Дадлага хийх хугацаанд дадлага удирдсан багш нарт тавих хяналтыг сайжруулж, 3-н талт гэрээг баримтлан суралцагчдын ажлын байранд олгох чадамжийг үр дүнтэй зохион байгуулахад анхаарч ажиллах
 - Дадлагын хугацаанд дадлага удирдсан багш нарт сургалтын албаны зүгээс хяналт тавин ажиллаж үйлдвэрлэлийн дадлагын гурвалсан гэрээг 4 байгууллагатай байгуулан дадлагын үр дүнг дүгнэн ажилласан байна. Мөн хамтран ажиллагч байгууллагуудад дадлагын удирдамжийн дагуу ажлуулах дадлагыг үр дүнтэй хийлгэх талаар санал шаардлага тавин ирцийг ДУБагш бүртгэж 81 суралцагчаас 60 суралцагч буюу 74 хувь нь дадлагад хамрагдсан байна.
2. Сангийн хөрөнгөөр бэлтгэсэн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах
 - Сангийн хөрөнгөөр бэлтгэсэн эд зүйлсийг зүй зохистой ариг гамтай ашиглан зарцуулж хариуцсан эзэн бүртэй зохих хариуцлага тооцон хараа хяналт тавин зориулалтын газар зааврын дагуу хадгалж байна.

2.3. ДАВТАН АУДИТААР 2017 ОНЫ 3-УЛИРЛЫН БАЙДЛААР САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАХАД ЗӨРЧЛҮҮД ДАВТАН ГАРСАН БАЙНА.

Булган МСҮТөв:

Давтан аудитаар 2017 оны 01 сараас 06 сарын 30-ны байдлаар МБСДСангийн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган шалгахад АШБ-ын бүрдэл дутуу 19 ажил гүйлгээгээр 27,725.1 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн ба давтан аудитын явцад 9 ажил гүйлгээний 13,846.8 мянган төгрөгийн баримтын бүрдлийг хангуулан зөрчлийг залруулсан. 10 ажил гүйлгээний 13,878.3 мянган төгрөгийн зөрчлийг залруулаагүй зөрчлөөр тооцлоо. Энэ нь Нягтлан бодох



бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7² дахь заалтыг зөрчиж байгаа тул зөрчлийг давтан гаргахгүй байх, АШБ-ын бүрдэл дутуу гүйлгээг таслан зогсоож, баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах талаар албан шаардлага хүргүүлж байна.

Архангай МСҮТөв:

Давтан аудитаар 2017 оны улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт, багш ажилчдын цалингийн тооцоолол, үндсэн хөрөнгийн ашиглалт, шинээр элсэн суралцагчдын тоог тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. 2017 оны 01 сараас 08 дугаар сарын 30-ныг дуустал харилцахын баримтыг тулган шалгахад АШБ-ын бүрдэл дутуу 22 ажил гүйлгээгээр 20,047.9 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн ба аудитын явцад баримтын бүрдэлийг хангуулан зөрчлийг залруулсан.
2. 2017 оны 01 дүгээр сараас 03 дугаар сар хүртэл багш, ажилчдын цалинг түүвэрлэн шалгаж, давтан тооцоолоход татвар ногдох шууд бус орлого болох хоолны мөнгийг үндсэн цалин дээр нэмж тооцсон зөрчил илэрсэн.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3³ дахь заалттай нийцэхгүй байгаа тул хоолны мөнгийг багш, ажилчдын цалингийн цэснээс тусад нь тооцож шимтгэлийг хуулийн дагуу суутгаж тайлагнах талаар хугацаатай албан шаардлага хүргүүлж байна.

3. 2017-2018 оны хичээлийн жилд тус МСҮТөвийн 200 хүүхдийн хүчин чадалтай 3 давхар 66 өрөө бүхий дотуур байранд өнөөгийн байдлаар бүртгэлтэй 61 хүүхэд байгаагаас байнга амьдарч байгаа 35-40 хүүхэд байна. Хүчин чадлын хувьд дөнгөж 20 хувийг л ашиглаж байна гэж үзэхээр байна. Гэтэл тухайн дотуур байрны ашиглалттай холбоотой зардлууд бүрэн зарцуулагдаж байна. Халаалтын зардал байрны хүчин чадлын хэмжээгээр бүрэн зарцуулагдаж, харин ус цахилгааны зардал хэрэглэсэн хэмжээгээр гарч байна. Энд төсвийн хөрөнгө тодорхой хэмжээгээр үр ашиггүй зарцуулагдаж байгаа бөгөөд нарийн тооцох боломжгүй байна.

Иймд үндсэн хөрөнгийн ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийг зохистой удирдахад чиглэсэн арга хэмжээ авч гарц шийдлийг олоход онцгой анхаарах талаар зөвлөмж хүргүүлж байна.

4. МСҮТөвийн дотуур байранд 100 хүүхэд байрлахаар батлагдснаас гүйцэтгэлээр 60 хүүхэдтэй байгаа тул хоолны зардал 5.1 сая төгрөгөөр зарцуулагдахааргүй үлдэгдэхээр байна.

Иймд уг зардлын үлдэгдлийг Төсвийн тухай хуулийн 45.2 дахь заалтын дагуу төсвийн орлогын дансанд төвлөрүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлж байна.

² НББТухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”

³ 15.1 “Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараахь бараа, үйлчилгээний орлогыг албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна”

15.1.3 “бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор”



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Давтан аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитаас хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах дүгнэлтийг хийлээ.

1. ӨМНӨХ АУДИТААС ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ 87.3 ХУВЬТАЙ БАЙНА.

1.1 Төлбөрийн актны 25 хувийг хэрэгжүүлээгүй байна.

1.2 Зөрчил арилгуулах албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

1.3 Зөвлөмжийн 13 хувийг хэрэгжүүлээгүй байна.

2. АУДИТЫН МӨРӨӨР ТОДОРХОЙ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСАН Ч ҮР ДҮН БАГАТАЙ БАЙНА

2.1 Аудитын дүнд үндэслэн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж ажилласан байна.

2.2 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр тодорхой ажлууд хэрэгжүүлсэн боловч үр дүнг тооцож ажиллаагүй байна.

2.3 Давтан аудитаар 2017 оны 3-улирлын байдлаар санхүүгийн үйл ажиллагааг шалгахад зөрчлүүд давтан гарсан байна.

Дээрх бүлгийн дүгнэлтүүдийг нэгтгэн дараах ерөнхий дүгнэлтийг өглөө.

ӨМНӨХ АУДИТААС ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ 87.3 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙГАА Ч ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ ЗАРИМ МСҮТ-ҮҮДЭД ГАРСАН БАЙНА.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Архангай МСҮТөвд:

1. Санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад журам зааварт нийцүүлэн тайлан мэдээг гаргаж ажиллах
2. Үндсэн хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх, тогтмол зардлыг бууруулах, төсвийг зохистой удирдахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллах
3. МСҮТөвийн дотуур байранд 100 хүүхэд байрлахаар батлагдснаас гүйцэтгэлээр 60 хүүхэдтэй байгаа тул хоолны зардал 5.1 сая төгрөгөөр зарцуулагдахааргүй үлдэгдэхээр байна. Иймд уг зардлын үлдэгдлийг Төсвийн тухай хуулийн 45.2 дахь заалтын дагуу төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар 20-ны дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлэх

Булган МСҮТөвд:

1. МБСДСангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, анхан шатны баримтын бүрдэлийг хангаж ажиллах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар 01-ний дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлэх

Тайлан бичсэн: Аудитор
Аудитор

Г.Цог-Эрдэнэ
Х.Алтанчимэг



ҮАГ-т санал уламжлах тухай

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар батлагдсан төлөвлөгөөний дагуу “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тэтгэлэг олгох журам”-ын хэрэгжилтэд давтан аудит хийлээ.

Энэ нь 2016 онд нэгдсэн удирдамжаар Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн нийцлийн аудитын мөрөөр төсвийн хөрөнгийн зарцуулалт, төрийн өмч хөрөнгийн ашиглалттай холбоотой дараах асуудлууд илэрлээ.

1. **Архангай** МСҮТөв нь 2015-2016, 2016-2017, 2017-2018 оны хичээлийн жилд 610-730 хүүхэд хамруулахаар 899.0-1071.8 сая төгрөгийн төсөв батлагдаж, санхүүжилт бүрэн хийгдсэн. Гэтэл суралцагчдын хамрагдалт 3 жилийн байдлаар 59-78 хувь буюу 428-475 хүүхэд хамрагдаж байна. Үүнээс болж суралцагчидтай холбоотой “Хичээл үйлдвэрлэлийн дадлага”, “хоол”- гэх мэт зардлууд тодорхой хэмжээгээр хэмнэгдэх нөхцөл бий болсон байна.
2. Тус МСҮТөвийн 200 хүүхдийн хүчин чадалтай 3 давхар 66 өрөө бүхий дотуур байранд дээрх хичээлийн жилүүдэд 40-74 хүүхэд байнга амьдарч байна. Өөрөөр хэлбэл дотуур байр хүчин чадлын хувьд 20-37 хувь нь ашиглагдаж байна.

Дээрх илрүүлэлтэд үндэслэн дараах саналуудыг тусгасан зөвлөмжийг Хөдөлмөр, Нийгмийн хамгаалалын яаманд уламжилж өгнө үү. Үүнд:

1. Архангай МСҮТөвийн төсвийн санхүүжилтийг олгохдоо элсэн суралцагчдын тоотой уялдуулан Төсвийн тухай хуулийн 45.2-г мөрдөж ажиллах.

Ингэснээр төсвийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдэлийг үнэн зөв тооцож, тодорхой хэмжээний хөрөнгө төсөвт төвлөрөх болно.

2. Архангай МСҮТ-ийн хувьд дотуур байрны ашиглалтыг сайжруулахад тодорхой арга хэмжээ авч ажиллах.

Ингэснээр хөрөнгийн ашиглалтын зардлыг хэмнэх боломжтой.

3. Цаашид дээрх асуудлуудтай холбоотой зөрчлийг давтан гаргахгүй байхад системийн хэмжээнд анхаарч ажиллах.



Холбогдох байгууллагын санал

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖИЛ
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

65135 Архангай аймаг, Эрдэнэбулган сум
Утас: (976) 9918-5800
Э-мэйл: ar.msut2017@gmail.com

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
АУДИТЫН ГАЗАРТ

2017.11.09 № 157

танай _____-ны № _____-г

Санал хүргүүлэх тухай

Танай байгууллагаас 2017 оны 01 сараас 08-р сарын 30-ыг дуустал харилцахын баримт, тэтгэлэг олгох журмын хэрэгжилтэнд хийсэн давтан аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

НББ-ын дагуу АШБ-ын бүрдлийг ханган тайлан мэдээнд бүрэн тайлагнаж ажилласан. Бараа материалыг худалдаж авахдаа бэлтгэн нийлүүлэгч түншлэгч байгууллагууд, хувь хүмүүсээс тендер зарлан материалыг авч хичээлийн жилд үнэлгээний хороо материалуудыг шалгаруулж, Түншлэл олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн Б.Түвшинтөр хариуцан ажилладаг. Шалгалтын явцад ТОНХА мэргэжилтэн гэрээнүүдийг аудиторт өгч нэг бүрчлэн танилцуулсан. АШБ-ын бүрдэл дутуу гэж үзэж байгаа зөрчлийг нийт хэдэн төгрөгний хичнээн гүйлгээ хийгдсэнээс хэдэн хувийг эзэлж байгаагаар гаргах нь зүйтэй гэсэн саналтай байна.

Сурагчдын элсэлтийн тоог нэмэгдүүлэхээр сургууль удирдлагын зүгээс олон ажлыг зохион байгуулсан ба сумдын Засаг даргын тамгын газар, сургуулийн захирал, хамт олон сурагчид, багийн засаг дарга нартай нэг бүрчлэн уулзаж судалгаа гарган сургууль сурталчлах, ажлуудыг зохион байгуулан ажилласан ба захирал 5 хүний бүрэлдэхүүнтэй 12 суманд ажиллаж элсэлт тодорхой хувиар нэмэгдэж байна.

- 2016-2017 оны хичээлийн жилд Мэргэжлийн боловсролд элсэх насны хүүхдийн тоо төрөлттэй холбоотой цөөрсөн байна.
- Аймагт 4 МСҮТ үйл ажиллагаа явуулж ижил мэргэжлээр элсэлт авч байгаатай холбоотой элсэгчдийн тоо бага байна.
- Тэтгэлэг олгохгүй болсноор хүүхдийн тоо цөөрсөн.

Дотуур байрны ашиглалтыг сайжруулах чиглэлээр дараах өрөөнүүдийг шинээр тохижуулж ашиглалттай болголоо. Үүнд:

- | | |
|-------------------------------|--------------------------------------|
| -Буудлын 4 өрөө | -Оёдлын анги |
| -Автын засварчины анги | -Чийрэгжүүлэлтийн өрөө |
| -Эрүүл мэндийн сургалтын өрөө | -Байрны сурагчдын спортын өрөө зэрэг |

өрөөнүүдийг ашигладаг болсон.

Дотуур байрны гэрэл цахилгааны зардлыг бууруулах зорилгоор ашиглалтгүй байгаа өрөө, тасалгаа, давхруудын гэрлийг бүрэн унтрааж, байрны багш нар хариуцан ажиллаж байна.

Мөн байранд түрээсээр амьдрах багш, ажилчдын судалгааг авсан боловч аймгийн төвд суурьшсан гэр бүл, хүмүүс байгаа тул алслагдсан байранд суух санал ирэхгүй байна.

Өмнөх аудитаар тавигдсан тэтгэлгийн төлбөрийг сургалтын алба, анги удирдсан багш нартай 5 удаа уулзан чирэгдэлгүйгээр барагдуулахыг удаа дараа шаардан ажилласан боловч тодорхой шалтгааны улмаас өдий хүрсэн. Дахин багш нартай уулзаж 12-р сард барагдуулахаар тохиролцон гарын үсэг зуруулав.

Хавсралт 1

ЗАХИРАЛ



Д.ТУНГАЛАГ



**"ГУРВАН ТАМИР" МЭРГЭЖИЛ
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ**

65130 Цэцэрлэг хот, Архангай аймаг

Утас/Факс: (976) 7033-2355

И-мэйл: 3tamiryamgerel@gmail.com

www.gurvantamir.edu.mn

2017. 11. 06 № 27/45
танай 254 -ны № харуу -т

АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн
төвийн тэтгэлэг олгох журмын хэрэгжилтийн
"давтан аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа. Тайлангийн төсөлд оруулах санал
байхгүй байна. Цаашид аудитын газраас өгсөн
зөвлөмжийн дагуу санхүүгийн үйл ажиллагаа
явуулах болно.

ЗАХИРАЛ.  НЯМГЭРЭЛ





а. Уугармаг
Аудитын газар
**АРХАНГАЙ АЙМАГ
БУЛГАН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ**
65139 Цэцэрлэг, Архангай аймаг УБД200604
Утас: 7033-2934 Факс: 7033-2934
E-mail: bulganmsut@yahoo.com
2017. 11. 07 № 110
танай _____ -ны № _____ -т *9/25*

Г АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР -Т

Аймгийн Аудитын газраас тус сургуульд хийсэн давтан аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тус сургуулийн 2016-2017 оны суралцагчдын хувьсах зардлын зарцуулалтанд хийгдсэн шалгалтын дүнтэй санал нийцэж байна. Шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж Аудитын газраас ирүүлсэн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАХИРАЛ



Д. МӨНГӨНЦЭЦЭГ



Аудитаас өгөгдсөн албан шаардлага



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 02/05 АРХ-2017/03-НА-ДА

Цэцэрлэг

Зөрчил арилгах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын Ерөнхий аудиторт Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тэтгэлэг олгох журмын хэрэгжилтэд хийсэн давтан аудитаар Архангай МСҮТөвд дараахи зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өмнөх аудитаас актаар тогтоосон 809.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Актны товч утга: 2015-2016 оны хичээлийн жилд давхардан суусан 6 суралцагчийн 3 сарын тэтгэлийн санхүүжилт болох 809.1 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх.
2. 2017 оны 01 дүгээр сараас 03 дугаар сар хүртэл багш, ажилчдын цалинг түүвэрлэн шалгаж, давтан тооцоолоход татвар ногдох шууд бус орлого болох хоолны мөнгийг үндсэн цалин дээр нэмэж тооцсон зөрчил илэрсэн

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 15.1.3-д "бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор"-ыг шууд бус орлогод хамааруулан тооцон гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны а/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.7-д "хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Багш, ажилчдын хоолны мөнгийг цалингийн цэснээс тусад нь тооцож, шимтгэлийг хуулийн дагуу суутган тайлагнах, өмнөх аудитаас өгсөн актыг бүрэн төлж барагдуулан, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 15-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Архангай МСҮТөвийн захирал Д.Тунгалаг, нягтлан бодогч Д.Жаргалсайхан нарт даалгав.

ӨГСӨН²:

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТОР *[Signature]* /Г.ЦОГ-ЭРДЭНЭ/

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

АРХАНГАЙ МСҮТӨВИЙН ЗАХИРАЛ
[Signature] /Д.ТУНГАЛАГ/

НЯГТЛАН БОДОГЧ *[Signature]* /Д.ЖАРГАЛСАЙХАН/

² Албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй, илэрсэн зөрчлийг арилгаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-г "... зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага зөв бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэсэн заалтын дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар зөв бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 01/94 АРХ-2017/03-НА-2А.

Цэцэрлэг

Зөрчил арилгах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын Ерөнхий аудиторт Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тэтгэлэг олгох журмын хэрэгжилтэд хийсэн давтан аудитаар Булган МСҮТөвийн 2017 оны хувьсах зардлын зарцуулалтаар 13,878.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2017 оны 01 сараас 06 сарын 30-ныг дуустал МБСДСангаас олгосон санхүүжилтийн зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган шалгахад АШБ-ын бүрдэл дутуу 19-н ажил гүйлгээгээр 27,725.1 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн ба давтан аудитын явцад 9-н ажил гүйлгээний 13,846.8 мянган төгрөгийн баримтын бүрдэлийг хангуулан зөрчлийг залруулсан. Үлдэгдэл 10-н ажил гүйлгээний 13,878.3 мянган төгрөгийн зөрчлийг залруулаагүй зөрчлөөр тооцлоо.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны а/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохин ёсоор хөтлөөгүй", 4.1.7-д "хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Анхан шатны нотлох баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж байгаа байдлыг таслан зогсоох, баримтын бүрдүүлэлтийг ханган ажиллаж, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Булган МСҮТөвийн гүйцэтгэх захирал Д.Мөнгөнцэцэг, нягтлан бодогч Б.Азонтунгалаг нарт даалгав.

ӨГСӨН ² :	АЛБАН ШААРДЛАГЫГ	ЗӨВШӨӨРСӨН:
АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОР	БУЛГАН МСҮТӨВИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ	Д.МӨНГӨНЦЭЦЭГ/
Г.ЦОС-ЭРДЭНЭ/	НЯГТЛАН БОДОГЧ	Б.АЗАНТУНГАЛАГ/

² Албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй, илэрсэн зөрчлийг арилгаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т "... зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэсэн заалтын дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



Discussion

Найдены следующие материалы:

Аудитын код: АРХ.201703-НА.ДА
Аудитын код: Мэргэлийн сур

Маргэжлэйн сургалт үйлдвэрлэлийн төвийн тэтгэлэг олгох журмын хэрэгжлэлийн давтан зурд

[illegible]



Үндсэн хөрөнгийг бүрэн ашиглах, тогтмол зардалыг бууруулах зорилготой арга хэмжээ ажилласан уу.	Дотуур байр 200 хуудайн хүчин чадлтай	2017-2018 оны хичээлийн жилд тус МСУТ-ийн 200 хуудайн хүчин чадлтай 3 давхар 66 өрөө бүхий дотуур байранд өнөөгийн байдалаар бүртгэлтэй 61 хуудад байгаагаас байгаа амьдрал байгаа 35-40 хуудад байна. Хүчин чадлын хувьд дөнгөж 20 хууийг л ашиглаж байна гэж үзэхээр байна.	Архангай аймагт 4 МСУТ-ий үйл ажиллагаа явуулдаг мөн суралцагчдын татгалзат олголт тодорхойгүй хугацаагаар зогсоогтой холбоотой.	Дотуур байрны ашиглалттай холбоотой зардлууд бүрэн гарсаар байна.	Төсвийн хөрөнгө тодорхой хэмжээгээр үр шалтгүй зарчуулагдаж байгаа бөгөөд нөхөн тоосрох боломжгүй байна.	Үндсэн хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх, тогтмол зардалыг бууруулах, төсвийн зогсолтой үндсэндээ чиглэсэн арга хэмжээ ажилласан.	
Тухайн жилд МСУТ-ийн хамруулахаар батлагдсан хуудайн тоо гүйцэтгэлээр бүрэн хамруулж байна уу.	2015-2016, 2016-2017, 2017-2018 оны батлагдсан төсөв	Архангай МСУТ-ий нь 2015-2016, 2016-2017, 2017-2018 оны хичээлийн жилд 610-750 хуудад хамруулахаар 899 0-1071.8 сан төгрөгийн төсөв батлагдаж, санхүүжилт бүрэн хийгдсэн. Гэвч суралцагчдын хамрагдалт 3 жилийн байдлаар 59-78 хувь буюу 428-475 хуудад хамрагдаж байна.		Суралцагчдад холбоотой зардлууд хэмнэгдэх нөхцөл бий болсон байна.	Архангай МСУТ-ийн ажил суралцах хуудайн тоо хангалтгүй байна.	МСУТ-ийн шимээр авсан суралцах суралцагчийн хувийг одоогийн түвшингээс 10-15 хувиар нэмэгдүүлэх.	

Аудитор:  (Хөндсөн)

Хөндсөн:  (Г. Байгалаа)

Аудитын мөнхлөг:  (Д. Уламбаяр)

Зөвшөөрсөн:  (Д. Уламбаяр)

Дарга, Тэргүүлэх аудитор:  (Д. Уламбаяр)



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/30

Цэцэрлэг

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2 дахь заалт, 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дахь заалт, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2017 оны 06 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тэтгэлэг олгох журам"-ын хэрэгжилтэд хийсэн давтан аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг www.audit.mn сайтад /Харьяа байгууллага – Архангай аймаг – аудитын тайлан – нийцлийн аудит хэсэгт/ бүрэн эхээр байршуулан аймгийн МСҮТ-дэд албан бичгээр мэдэгдсүгэй.
4. Давтан аудитын тайланд тусгагдсан албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын багийн аудитор /Х.Алтанчимэг/-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР





Архангай аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга
Төргүүлэх аудитын 2017 оны дугаар тушаалын хавсралт №1

Албан шаардлага, Зөвлөмжийн жагсаалт

№	Албан шаардлага, зөвлөмжийн жагсаалт		Мөнгөн дүн /сая.төг/	Аудитын шалдварыг хэрэгжүүлэх байгууллагын нэр
	Дугаар	Товч утга		
1	2017.11.01-ны өдрийн 02/95 АРХ-/2017/03-НА- ДА	Өмнөх аудитаас актаар тогтоогдсон төлбөрийг барагдуулаагүй, цалингийн тооцооллыг зөрүүтэй тооцсон	0.8	Архангай МСҮТөө
2	2017.11.01-ны өдрийн 01/94 АРХ-/2017/03-НА- ДА	Анхан шатны баримтын бүрдэл дутуу 10 ажил гүйлгээр хөрөнгө зарцуулсан.	13.9	Булган МСҮТөө
3	2017.11.21 01/14 АРХ- 2017/03-НА-ДА	МБСДСангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, анхан шатны баримтын бүрдэлийг хянгаж ажиллах	-	Булган МСҮТөө
4	2017.11.21 02/15 АРХ- 2017/03-НА-ДА	Санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад журам зааварт нийцүүлэн тайлан мэдээг гаргаж ажиллах Үндсэн хөрөнгийн өмчлөлийг нэмэгдүүлэх, тогтмол зардлыг бууруулах, төсвийг зохистой удирдахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллах МСҮТөвийн дотуур байранд 100 хүүхэд байрлахаар батлагдснаас гүйцэтгэлээр 60 хүүхэдтэй байгаа тул хоолны зардал 5.1 сая төгрөгөөр зарцуулагдахааргүй үлдэгдэхээр байна. Иймд уг зардлын үлдэгдлийг Төсвийн тухай хуулийн 45.2 дахь заалтын дагуу төсвийн орлогын дансанд төөлөрүүлэх	5.1	Архангай МСҮТөө
Дүн			19.8	



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨВЛӨМЖ

2017 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 01/14 АРХ-2017/03-НА-ДА

Цэцэрлэг

БУЛГАН МСҮТӨВИЙН
ЗАХИРАЛ Д.МӨНГӨНЦЭЦЭГ ТАНАА

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын Ерөнхий аудиторт Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тэтгэлэг олгох журмын хэрэгжилт"-д давтан аудитыг хийлээ.

Аудитаар 2017 оны 01 сараас 06 сарын 30-ны байдлаар МБСДСангийн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган шалгахад АШБ-ын бүрдэл дутуу 19 ажил гүйлгээгээр 27,725.1 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн ба давтан аудитын явцад 9 ажил гүйлгээний 13,846.8 мянган төгрөгийн баримтын бүрдлийг хангуулан зөрчлийг залруулсан. 10 ажил гүйлгээний 13,878.3 мянган төгрөгийн зөрчлийг залруулаагүй зөрчлөөр тооцлоо.

Уг аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. МБСДСангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, анхан шатны баримтын бүрдэлийг хангаж ажиллах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨВЛӨМЖ

2017 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 02/15 АРХ-2017/03 - НА-ДА

Цэцэрлэг

АРХАНГАЙ МСҮТӨВИЙН
ЗАХИРАЛ Д.ТУНГАЛАГ ТАНАА

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын Ерөнхий аудиторт Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тэтгэлэг олгох журмын хэрэгжилт"-д давтан аудитыг хийлээ.

Уг аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад журам зааварт нийцүүлэн тайлан мэдээг гаргаж ажиллах
2. Үндсэн хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх, тогтмол зардлыг бууруулах, төсвийг зохистой удирдахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллах
3. МСҮТөвийн дотуур байранд 100 хүүхэд байрлахаар батлагдснаас гүйцэтгэлээр 60 хүүхэдтэй байгаа тул хоолны зардал 5.1 сая төгрөгөөр зарцуулагдахааргүй үлдэгдэхээр байна. Иймд уг зардлын үлдэгдлийг Төсвийн тухай хуулийн 45.2 дахь заалтын дагуу төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 20-ны дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР

44

